



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 05 сарын 26 өдөр

Дугаар 35

Мандалговь

Орон нутгийн өмчөөс төрийн өмчид хөрөнгө
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 5 дугаар зүйлийн 5.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит аравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймгийн Музейн сан хөмрөг, үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 750,000 /долоон зуун тавин мянга/ төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий “хүрэл тамга”-ыг Чингис хааны музейн үндсэн хөрөнгөд балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Гантулга), Музейн захирал (М.Бямбажав) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Музейн үзмэрийг төрийн өмчид шилжүүлэх ажлыг зохих хууль тогтоомж, журмын дагуу шийдвэрлүүлэх;

2.2. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;


2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодэх бүртгэж, тайланд тусгах.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  СОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн
35 дугаар тогтоолын хавсралт



Орон нутгийн өмчөөс төрийн өмчид балансаас балансад шилжүүлэх
хөрөнгийн мэдээлэл

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Хүрэл эдлэл	1969	1	750,000	-	750,000
Хөрөнгийн дүн				750,000 /Долоон зуун тавин мянга/ төгрөг		750,000 /Долоон зуун тавин мянга/ төгрөг